I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	375,983,509.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,983,509.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,011,429.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,279,028.64
210101	Үндсэн цалин	52,279,028.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,213,336.00
210201	Тэтгэврийн даатгал	7,162,936.00
210205	Эрүүл мэндийн даатгал	50,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,289,832.00
210303	Цэвэр, бохир ус	13,289,832.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,645,581.00
210401	Бичиг хэрэг	2,789,520.00
210402	Тээвэр, шатахуун	10,735,261.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00
210404	Ном, хэвлэл	2,230,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,850,400.00
2105	Нормативт зардал	116,807,409.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,426,009.00
210502	Хоол, хүнс	14,515,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,866,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,437,500.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	24,223,500.00
210602	Тавилга	3,889,000.00
210604	Урсгал засвар	5,325,000.00
2107	Томилолт, зочны зардал	49,400.00
210702	Дотоод албан томилолт	49,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,489,343.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,489,343.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,972,080.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,712,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,712,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,260,080.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,260,080.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	379,136,711.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	379,136,711.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,020,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,289,819.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	231,838,552.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,988,340.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,153,201.36

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Я.Анхтулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 15 -аас 2022 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 1/25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлсэн тогтвортой эдийн засгийг бий болгон, эдийн засгийн суурь хөгжлийг ХАА, түүний дотроос мал аж ахуй дээр суурилан хөгжүүлэх” гэж тодорхойлсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын ТТЗ санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Түвшинширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрэх магадлалтай байна.

2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна. Түвшинширээ сумын ТТЗ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 4,035.2 сая төгрөгийн зардлын 1.5 хувь буюу 60.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 175.5 сая, эцсийн үлдэгдэл 264.4 сая төгрөг болж, 88.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Арилжааны банкны харилцах	0.2	18.3	18.1	7.0
Төрийн сангийн харилцах	175.3	246.1	70.8	93.0
Дүн	175.5	264.4	88.9	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эх сурвалж: Түвшинширээ сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 264.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 18.3 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна. Үүнээс:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогын үлдэгдэл 43.1 сая;
- Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл 39.2 сая;
- Эрүүл мэндийн төвийн үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 3.4 сая;
- Төрийн сангийн ерөнхий орлогын (910) дансны үлдэгдэл 160.4 сая;
- Эмийн эргэлтийн сангийн арилжааны банкны үлэгдэл 18.3 сая төгрөг байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 238.4 сая, эцсийн үлдэгдэл 281.6 сая төгрөг болж, 43.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1.1	1.1
Зээлийн хүүгийн авлага	12.2	13.2	1.0
Бусад авлага	224.4	267.0	42.6
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1.8	0.3	-1.5
Дүн	238.4	281.6	43.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд татаас, санхүүжилтийн авлага 49.4 сая төгрөг буюу 17.5 хувь, Сум хөгжүүлэх сангаас иргэн, хуулийн этгээдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 232.2 сая төгрөг буюу 82.5 хувийг эзэлж байна.

Татаас, санхүүжилтийн авлага нь тайлант онд ЭМДС-аас Эрүүл мэндийн төвд олгох 34.7, ажиллагсадтай холбогдсон авлага 1.1, татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ 0.3, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны 3.3/худгийн ажилтны хөлс олгох/, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 10.0 сая төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлснээс үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

- *Тайлант оны эцэст 1,107.4 мянган төгрөгийн НДШ-ийн авлагын үлдэгдэлтэй буюу төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй, харилцагч байгууллагад шилжүүлж, авлага үүсгэсэн зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ЗДТГ/*
- *Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар 11,475.0 мянган төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэсэн байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй зөрчлийг аудитын явцад залруулсан. /ОНХС/*

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 210.8 сая, эцсийн үлдэгдэл 232.6 сая төгрөг болж, 21.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	10.6	14.1	3.5
Эм боох материал	35.8	24.2	-11.6
Бичиг хэргийн материал	9.1	10.3	1.2
Аж ахуйн материал	124.4	138.2	13.8

Сэлбэг хэрэгсэл	4.5	4.5	0.0
Түлш тослох материал	3.4	3.8	0.4
Барилга засварын материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	1.5	5.6	4.1
Бусад хангамжийн материал	6.6	16.7	10.1
Мал амьтад	14.9	15.2	0.3
Дүн	210.8	232.6	21.8

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 232.7 сая төгрөгийн үлдэгдэлд аж ахуйн материал, тусгай зориулалт, бусад хангамжийн материал, бичиг хэрэг болон мал амьтдын үлдэгдэл гол нөлөөлж байна. Мөн бараа материалын үлдэгдлийн эм боох материал нь ЭЭСан, аж ахуйн материалын 46 хувийг ЕБСургууль, 30 хувийг СӨБ, 11 хувийг Соёлын төв, 6.1 хувийг ЭМТ зэрэг байгууллагууд эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд худалдан авч цар тахлын өвчний үед ашиглах халууны шил, ариутгалын бодис, хамгааллын хувцас, хэрэглэл болон аж ахуйн материал худалдан авсан нь үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,451.6 сая, эцсийн үлдэгдэл 8,378.2 сая төгрөг болж, 1,926.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	4,266.7	5,867.8	1,601.0
Тээврийн хэрэгсэл	285.7	440.4	154.7
Машин тоног төхөөрөмж	613.4	666.3	52.9
Тавилга эд хогшил	170.2	203.2	33.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйл			-
Номын фонд	43.8	47.2	3.4
Бусад үндсэн хөрөнгө	976.2	1,057.9	81.7
Программ хангамж	1.5	1.5	-
Бусад биет бус хөрөнгө	93.9	93.9	-
Дүн	6,451.6	8,378.2	1,926.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 138.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан бол хандив тусламж бусад эх үүсвэрээр 1,788.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Хандив тусламжаар ирсэн хөрөнгийг авч үзвэл:

- **Хүүхдийн цэцэрлэг ОНХС-аас 2.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж /камер/ үнэгүй ирснийг данс бүртгэлд тусгажээ.**
- **Ерөнхий боловсролын сургууль: БШУЯ-аас 3.0 сая төгрөгийн ном, бусад эх үүсвэрээс 8.5 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж үнэгүй ирснийг данс бүртгэлд тусгажээ.**
- **Засаг даргын тамгын газар: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /ОНХС/ 255.6 сая төгрөгийн өвсний фондын хашаа, тээврийн хэрэгсэл зэрэг бусад хөрөнгийг бүртгэж, хүлээн авчээ.**
- **Эрүүл мэндийн төв: Дээд шатын төсөв захирагч болон ЭМГ-аас Коронавирус цар тахлын хүрээнд 14.9 төгрөгийн рентген аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгч зэрэг тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй, хандив тусламжаар олгосон байна.**

- **Соёлын төв:** Улсын төсвийн хөрөнгөө оруулалтаар баригдсан 1,504.6 сая төгрөгийн соёлын төвийн барилга үнээгүй ирснийг данс бүртгэлд тусгажээ.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой 76.3 сая төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 76.3 сая төгрөгийн 1 алдаа зөрчлийг залруулж, 2 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7 зөрчилд зөвлөмж өгсөн.

Албан шаардлага

- Тооллогын комисс эд хөрөнгөө нэг бүрийг бодитой үнэлж, тоолоогүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж, баталгаажуулаагүй, бараа материалын тайланг үнэн зөв бэлтгэж толилуулаагүй, материалыг нэр төрөл, тоо ширхгээр орлого авч зарлага болгоогүй, анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж тайлагнаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;

Зөвлөмж

- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 422 нэр төрлийн хөрөнгөө бүртгэлтэй байна;
- Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгөө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах
- Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.
- Орон нутгийн төсвөөр хийгдэх хөрөнгөө оруулалт, төсөл арга хэмжээний 76.3 сая төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгээгүй зөрчлийг аудитын явцад залруулсан

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 29.6 сая, эцсийн үлдэгдэл 10.8 сая төгрөг болж, 18.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой өглөг	0.0	4.0	4.0	21.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-	-
Байгууллагад төлөх	11.7	4.1	-7.6	-40.4
Хувь хүнд төлөх	-	2.7	2.7	14.3
Татварын өглөг/ТӨҮГ/	-	-	-	-
Дансны өглөг/ТӨҮГ/	17.9	-	-17.9	-95.2
Бусад урьдчилж орсон орлого	-	-	-	-
Нийт дүн	29.6	10.8	-18.8	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд 10.8 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүссэн байна.

Үүнд:

- Ажилчидтай холбоотой 4.0 сая төгрөгийн өглөг үүсэн байна. Энэ нь санхүүжилт бүрэн олгогдоогүй / ЭМТ 2.4 сая/, ажилгүй байсан хугацааны нөхөн олговор олгосноос цалингийн санд / Соёлын төв 1.6 сая / өр төлбөр үүсэн.
- **Засаг даргын тамгын газар:** *Нэмэлт санхүүжилтийн дансны 2.6 сая /худгийн ажилтны хөлс олгох, 0.2 сая / тээврийн хөлс олгоогүй / төгрөгийн өглөг үүссэн.*
- *Хувь хүнд тээврийн хөлс олгоогүй 0.7 төгрөгийн өглөг үүссэн байна. /ЭМТ/*

3.5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,759.8 сая, эцсийн үлдэгдэл 7,482.8 сая төгрөг болж, 1,825.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,107.6	2,107.6	-	-
Хуримтлагдсан үр дүн	3,001.1	4,826.8	1,825.7	100
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	621.5	621.5	-	-
Дүн	5,730.2	7,555.9	1,825.7	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын дансны үлдэгдэл өсөхөд тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

3.5.7 Орлогын данс

Татварын болон татварын бус орлого 260.7, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,858.5, зээлийн хүүгийн орлого 6.0, төсөвт байгууллагын өөрийн орлого 5.1, борлуулалтын орлого 275.5, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 1,668.0, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 162.3, нэмэлт санхүүжилтийн орлого 372.5, орон нутгийн төсвөөс санхүүжих 1431.7, эрүүл мэндийн даатгалын сангаас 56.0 сая нийт 6,096.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

3.5.8 Зардлын данс

Тайлант онд гарсан нийт зардлаас цалин хөлс нэмэгдэл урамшлын зардалд 1,755.3 сая буюу 43.4 хувь, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 232.9 сая буюу 5.8 хувь, бараа үйлчилгээний бусад зардалд 603.5 сая буюу 15.0 хувь, урсгал шилжүүлэг 842.5 сая буюу 20.8 хувийг эзэлж байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг бусад зардалд 606.1 сая төгрөг буюу 15.0 хувийг тус тус зарцуулсан байна.

Зардлын данстай холбоотой холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй 149.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Төлбөрийн акт

- *Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалт бус зарцуулсан 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ОНХС/*

Албан шаардлага

- Үндсэн хөрөнгө худалдан авах, шагнал, урамшуулал, уралдаан тэмцээнд хөрөнгө зарцуулж МУ-ын Засгийн газрын 2021 оны 43 тоот тогтоолоор баталсан төсвийн хэмнэлтийн горимыг зөрчсөн. /ЗДТГ 20.8 сая/
- Төлбөрийн цахим систем"-д нийт 123.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээний төлбөр баримт шивээгдээгүй, Эрүүл мэндийн үзлэг шинжилгээний төлбөрт анхан шатны баримтын иж бүрдэл дутуу зэрэг зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэв. /ОНХС 128.2 сая/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 81.1 сая төгрөг, татварын бус орлого 21.0 сая нийт 102.2 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр татварын орлого 225.8 сая төгрөг, татварын бус орлого 34.9 сая төгрөг нийт 260.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын гүйцэтгэл 158.5 сая төгрөгөөр давсан байна. Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өссөн /Буурсан/
НИЙТ ОРЛОГО	102.2	260.7	158.5
ТАТВАРЫН ОРЛОГО	81.2	225.8	144.6
Хувь хүний орлогын албан татвар	35.1	65.8	30.7
Үйл ажиллагааны орлого	1.1	28.5	27.4
Хөрөнгийн орлого	16.0	23.5	7.5
Хөрөнгийн борлуулсны орлого	0	4.3	4.3
Шууд бус орлого	18.0	9.5	-8.5
Хөрөнгийн албан татвар	36.3	98.0	61.7
Бууны албан татвар	1.3	1.4	0.1
Малд ногдуулах албан татвар	35.0	96.6	61.6
Бусад татвар (төлбөр, хураамж)	9.8	62.0	52.2
Улсын тэмдэгтийн хураамж	1.3	0.6	-0.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.3	1.6	1.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2.0	3.8	1.8
Газрын төлбөр	6.0	0.8	-5.2
Агнуурын нөөц ашигласны төлбөр	0	54.6	54.6
Ус рашаан ашигласны төлбөр	0.2	0.5	0.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21.0	34.9	13.9
Хүү, торгуулийн орлого	11.0	9.9	-1.1
Ангилалдаагүй бусад орлого	10.0	25.0	15.0

Орон нутгийн төсөвт төвлөрөх орлого 158.5 сая төгрөгөөр давсан нь тайлант онд ан агнуурын нөөц ашигласны төлбөр 54.6 сая, малын тоо толгойн албан татвар 61.6 сая төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлжээ.

Ан агнуурын нөөц ашигласны төлбөр төлөвлөснөөс давсан нь гадаадын иргэн БОАЖЯ-аас олгосон зөвшөөрлийн дагуу шонхор шувуу барьж, төлбөр төлсөн, малын тоо толгойн

албан татвар 61.6 сая төгрөгөөр давж биелэхэд нөлөөлсөн байна. Мөн үйл ажиллагааны орлого 27.4 сая, ангилагдаагүй бусад орлого 15.0 сая төгрөгөөр давсан бол төлөвлөгдөөгүй хөрөнгө борлуулсны 4.3 сая төгрөгийн татварын орлого төвлөрсөн байна.

Харин орон нутгийн төсвийн орлогоос дараах орлого 0.7-8.5 сая төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

- ✓ *Газрын төлбөр 5.2 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь газрын төлбөрт 6.0 сая төгрөг төлөвлөн 2 талбар газрын дуудлага худалдааг зохион байгуулсан боловч төлбөр нь аймгийн орлогод орсон нь орлого тасрахад нөлөөлсөн байна.*
- ✓ *Бусад татвар 8.5 сая төгрөгөөр тасарсан нь шууд бус орлогод орохоор төлөвлөсөн ноос ноолуурын урамшууллын 10 хувь үйл ажиллагааны орлогод орсноос шууд бус орлогын төлөвлөгөө 8.5 сая төгрөгөөр тасарсан харагдаж байна.*

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 онд татварын орлогыг 76.2 сая, татварын бус орлогыг 21.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн татварын орлогыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 81.2 сая, татварын бус орлогыг 21.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Засаг даргын хүргүүлсэн төсвийн татварын орлогыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Үүнд: малын тоо толгойн албан татварын нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,910.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,547.1 сая төгрөгийг урсгал зардалд, 283.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 80.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 851.5, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,657.5, Эрүүл мэндийн даатгалын сангаас 21.3, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 162.3, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 79.0 сая нийт 2,771.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,804.2 сая төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Үүнд: Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн этгээдээс авсан хандив, тусламж 1.0 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 104.3, дээд шатны төсвийн захирагчаас 2.9, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 270.9 сая нийт 379.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, урамшуулал, шимтгэлд 59.5, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13.3, хангамж, бараа материалын зардалд 17.6, нормативд зардалд 116.8, эд хогшил, урсгал засварын зардалд 33.5, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 0.8, бараа үйлчилгээний бусад зардалд 104.5, урсгал шилжүүлэгт 30.0

сая нийт 376.0 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 3.1 сая төгрөгийг авлага үүсгэн төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн шууд захирагч нарын шилэн дансны мэдээллийн авч үзвэл, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мэдээллийг дутуу мэдээлсэн, өглөг, авлагын мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Тухайлбал:

- **ЗДТГ:** Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 зарлагын гүйлгээний 12.4 сая, урсгал санхүүжилтийн 15 гүйлгээний 261.3 сая төгрөгийг мэдээлээгүй
- **Цэцэрлэг:** Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 зарлагын гүйлгээний 45.0 сая, урсгал санхүүжилтийн 29 гүйлгээний 448.7.1 сая төгрөгийг мэдээлээгүй
- **ЭМТ:** таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 78 зарлагын гүйлгээний 12.4 сая, урсгал санхүүжилтийн 21 гүйлгээний 591.2 сая төгрөгийг мэдээлээгүй

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй тул албан шаардлагын хүргүүлэв.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	1	-	0	-	-	-	0
Нийт	1	-	0	-	-	-	0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 орон нутгийн тусгайн сан, 1 эмийн эргэлтийн сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 237.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1.3 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 148.8 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүллээ. Аудитын явцад 87.7 сая төгрөгийн хөрөнгийг авлага болон үндсэн хөрөнгийн санхүүгийн тайланд илэрхийлээгүйг залруулсан.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар биологийн хөрөнгө болох мал амьтадыг бодит үнэ цэний аргаар санхүүгийн тайланд толилуулах, ОНХС-аар хийгдсэн

хөрөнгө оруулалтын ажлуудыг ЗДТГ-т бүртгэх бус тус санд нь захиалагчийн зүгээс бүртгэж байгаа байдлыг хамруулан авч үзэхээр төлөвлөж байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт:

4.1.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэний аргаар толилуулаагүй нийтлэг алдаа илэрсэн.

4.1.2 Эрсдэл: НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.2.1 Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.2.3 Өгсөн зөвлөмж

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар нийт 237.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1.3 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 148.8 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүллээ. Аудитын явцад 87.7 сая төгрөгийн хөрөнгийг авлага болон үндсэн хөрөнгийн санхүүгийн тайланд илэрхийлээгүйг залруулсан.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

2022.03.25	Аудитын нэр:	Түвшинширээ сумын Засаг даргын тайлан	Аудитын код:	СБА-2022/09/НА-СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Түвшинширээ сумын Засаг дарга		Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгө н дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.	-	Албан шаардлага	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Я.Анхтулга Б.Мөнхдэлгэр
2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэний аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан.		Зөвлөмж	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Я.Анхтулга Б.Мөнхдэлгэр
3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.		Зөвлөмж	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Я.Анхтулга Б.Мөнхдэлгэр
4	Харьяа төсвийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлж байна.	-	Зөвлөмж	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Я.Анхтулга Б.Мөнхдэлгэр
	Дүн	0			